

МОНГОЛБАНК

**ШПАРКАССЭ
БАНКНЫ САН**

**МОНГОЛЫН
БАНКНЫ
ХОЛБОО**

**ОСТПРИГНИТЦ-
РУППИНЫ
ШПАРКАССЭ БАНК**

ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ САНАМЖ БИЧИГ

2018 оны 11 дүгээр
сарын 1-ний өдөр

Улаанбаатар
хот

НЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

- 1.1 Энэхүү хамтын ажиллагааны санамж бичиг (цаашид “Санамж бичиг” гэх)-ийг Монголбанк (цаашид “МБ” гэх), Монголын Банкны Холбоо (цаашид “МБХ” гэх), Шпаркассэ Банкны Сан (цаашид “ШБС” гэх), Остпригнитц-Руппины Шпаркассэ Банк (цаашид “ОРШБ” гэх) нар дор дурдсан асуудлаар харилцан тохиролцон үйлдэв.
- 1.2 Хамтын ажиллагааны санамж бичгийн зорилго нь МБ, МБХ, ШБС, ОРШБ (цаашид “талууд” гэх) харилцагчид зөвлөх банкны мэргэжилтний онол практик хосолсон сургалт болон хүүхэд залуусын санхүүгийн боловсролыг дээшлүүлэх хөтөлбөрөөр МБ болон МБХ-г дэмжих, хамтын ажиллагааг нэгтгэн чиглүүлэхэд оршино.
- 1.3 Хамтын ажиллагаа нь хуулиар хориглоогүй асуудалд ил тод нээлттэй байх, хамтын ажиллагааны үр дүнг нэгтгэн хэлэлцэх, харилцан дэмжлэг үзүүлэх зарчимд тулгуурлан Төв банкны /Монголбанк/-ны тухай хууль, Холбооны Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн яамны (ЭЗХАХЯ) дүрэм, журам, Монгол Улсын бусад хууль тогтоомжийн заалтыг удирдлага болгоно.

ХОЁР. ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛ

Хамтын ажиллагаа нь дараах чиглэлтэй байна:

- 2.1 Монгол улсын банк санхүүгийн салбарын хөгжлийг банкны мэргэжилтний онол практик хосолсон сургалтаар болон хүүхэд залуусын санхүүгийн боловсролыг дээшлүүлэх хөтөлбөрөөр дамжуулан эрчимжүүлэхэд чиглэсэн ажлуудад хамтран оролцох;
- 2.2 Банкны мэргэжилтний онол практик хосолсон сургалт нь урт хугацаандаа банкны ажилтны суурь стандарт болоход дотоодын нөөц бололцоонд суурилсан, менежмент, санхүү, бүтэц зохион байгуулалтын хувьд бие даасан байх шаардлагатай. Түүнчлэн дотоодын мэргэжилтнүүдийн (төслийн хүрээнд бэлтгэгдсэн сургагч багш нар г.м.) оролцоотойгоор онол практик хосолсон сургалтын чанарыг тогтвортой байлгах;

- 2.3 Төсөлд идэвхтэй оролцож буй банкуудын мэргэжилтнүүд болон удирдах албан тушаалтнуудад зориулан хэрэгцээт сэдвийн дагуу (жишээ нь “CRM” буюу харилцагчийн сегментчлэл, эрсдэлийн удирдлага, бичил жижиг дунд бизнес г.м.) тусгайлсан семинарыг зохион байгуулах;
- 2.4 Хүүхэд залуучуудад санхүүгийн боловсрол олгох хүрээнд Дэлхийн хуримтлалын өдрийн аяныг үргэлжлүүлж, МБ болон арилжааны банкуудтай хамтран жил бүр аяны хамрах хүрээг тэлэх;
- 2.5 ШБС нь Санамж бичгийн хүрээнд түнш байгууллагуудад өөрсдийн санхүүгийн нэгдлийн туршлагаас хуваалцах;
- 2.6 Тогтвортой хөгжлийн зорилтуудын 3-н түвшинд (эдийн засаг, нийгэм, байгаль орчин) ажиллахыг талууд хүлээн зөвшөөрч байна. Эдийн засаг ба нийгмийн түвшин төслийн үйл ажиллагаанаас шууд хамааралтай. Түүнчлэн төслийн шийдвэр гаргалтууд байгаль орчинд ээлтэй байх;
- 2.7 МБ болон МБХ нь хагас жил тутамд ШБС-г (өөрсдийн санхүүгийн нөхцөл байдал, үйл ажиллагааны чиг баримжаа, томоохон өөрчлөлтүүд г.м.) мэдээллээр хангах.

ГУРАВ. САНХҮҮЖҮҮЛЭЛТ

3.1 Энэхүү Санамж бичгийн хүчин төгөлдөр байдал нь дараах 2 нөхцөл байдлаас хамаарна:

3.1.1 ЭЗХАХЯам төслийг санхүүжүүлсэн хэвээр байх.

3.1.2 Зохих хяналт тавих боломжгүй үйл явдал, нөхцөл байдал буюу давагдашгүй хүчин зүйлс төслийн зорилго болон хэрэгжүүлэлтэд нөлөөлөхгүй байх.

ДӨРӨВ. БУСАД ЗҮЙЛ

- 4.1 Талууд энэхүү санамж бичигт заасан үүргийг биелүүлж, бүрэн хариуцлага хүлээн ажиллана.
- 4.2 Талууд энэхүү санамж бичгээр харилцан тохиролцоогүй үүсэх маргааныг шүүхийн бус замаар, харилцан ойлголцолд суурилан, бие биенээ хүндэтгэх зарчмаар шийдвэрлэхийг зорино. Санамж бичгийг байгуулсан талууд нэг сарын өмнө бичгээр хүсэлтээ өгч, хамтын ажиллагааг зогсоох эрхтэй.
- 4.3 Хамтран гүйцэтгэх ажил үүргийг талууд тухайн тохиолдолд нарийвчлан тохиролцох бөгөөд тухайн ажил гүйцэтгэхэд талууд хоорондын харилцаанд энэхүү санамж бичгийг баримтална.
- 4.4 Энэхүү санамж бичиг гарын үсэг зурж баталгаажуулсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болох бөгөөд санамж бичигт өөрчлөлт оруулах, шинэчлэх талаар талууд санал гаргаагүй тохиолдолд 2021 оны 11 сарын 30-ны өдрийг дуустал хүчинтэй байна.
- 4.5 Энэхүү санамж бичгийн хугацаа дуусахад түүнийг сунгах буюу дахин шинээр байгуулж болно.

4.6 2018 оны 11 дүгээр сарын 1-ний өдөр монгол, англи хэлээр тус бүр 4 хувь үйлдэв. Монгол, Англи хувийг эрх тэгш хэмээн тооцно.

МОНГОЛБАНК




Б. ЛХАГВАСҮРЭН

Дэд ерөнхийлөгч

Бага тойруу 3, Чингэлтэй дүүрэг, 15160
Улаанбаатар, Монгол улс

ШПАРКАССЭ БАНКНЫ САН



НИКЛАУС БЕРГМАН

Гүйцэтгэх захирал

Симрокштрассэ 4,
53113 Бонн, ХБНГУ

МОНГОЛЫН БАНКНЫ ХОЛБОО



Ж. ҮНЭНБАТ

Гүйцэтгэх захирал

Виста оффис, Чингис Хааны өргөн
чөлөө 17, Сүхбаатар дүүрэг, 15160
Улаанбаатар, Монгол улс

ОСТПРИГНИТЦ-РУППИНЫ
ШПАРКАССЭ БАНК



МАРКУС РУЙК

ТУЗ-ын дарга

Фонтанэ платц 1,
16816 Нойруппин, ХБНГУ

**BANK OF
MONGOLIA**

**SPARKASSEN
STIFTUNG**

**MONGOLIAN
BANKERS
ASSOCIATION**

**SPARKASSE
OSTPRIGNITZ-RUPPIN**

MEMORANDUM OF UNDERSTANDING

1st of November, 2018

City of Ulaanbaatar

1. GENERAL TERMS

- 1.1 This Memorandum of Understanding (hereinafter “MoU”) is made and entered into by and between the Bank of Mongolia (hereinafter “BoM”), the Mongolian Bankers Association (hereinafter “MBA”), the Sparkassenstiftung für internationale Kooperation e.V. (hereinafter “Sparkassenstiftung”) and the Sparkasse Ostprignitz-Ruppin (hereinafter “Sparkasse OPR”) within the scope of work described below.
- 1.2 The overall goal of the MoU is for BoM, MBA, Sparkassenstiftung and Sparkasse OPR (together collectively referred to as “the parties”) to jointly support BoM and MBA through the dual vocational training for bank specialists as well as through the program aimed at increasing financial literacy of the young population in Mongolia.
- 1.3 The cooperation shall be guided by the respective legislation of Mongolia, the Central Bank law as well as the rules and regulations of the German Federal Ministry for Economic Cooperation and Development (hereinafter “BMZ”). The parties agree to act based on mutual support and understanding, will aim to be clear and open on matters as long as it is legally allowed, will discuss and evaluate project results collectively.

2. SCOPE OF COOPERATION

The cooperation will focus on the following:

- 2.1 Cooperation in strengthening the development of the banking and finance sector in Mongolia via the introduction of dual vocational training for bank specialists and the program aimed at increasing the financial literacy of young population in Mongolia;
- 2.2 In order for the dual training to become minimum standard for bank specialists, a preparation of prerequisites for taking over the processes (management, financially) through local structures is needed. In addition, a sustainable safeguarding of the quality of the dual vocational training for bank specialists by local experts is important;
- 2.3 Development and organisation of practice-oriented special courses for specialists and executives of the participating banks (in particular CRM including customer segmentation, risk management and MSME business etc.);

- 2.4 Continuation of the World Savings Day measures for the basic financial education of young people together with the banks and the BoM with regional and cross-bank expansion at least once a year;
- 2.5 Under this MoU, Sparkassenstiftung will make available the experience of its Finance Group to the partner institution wherever relevant;
- 2.6 The parties confirm that they are committed to work towards the fulfilment of the three dimensions of the Sustainable Development Goals (SDGs): the economic, social and environmental dimensions. The economic and social dimension derives directly from the project activities. In addition, the environment is a prerequisite for socio-economic development and therefore, always must be taken into consideration while making decisions within the project cooperation;
- 2.7 The BoM and the MBA agree to inform Sparkassenstiftung about its financial and technical performance as well as about major changes (that includes technical and financial cooperation arrangements made with any other donor institution) in its objectives and operations on a half year basis.

3. FINANCING

- 3.1 The effectiveness of this MoU is subject to:
 - 3.1.1 The financing of BMZ and the eventual release of the necessary funds for the mutual project.
 - 3.1.2 The fact that there will not arise any exceptional circumstances which preclude, or place in considerable jeopardy, the purpose of the project or its implementation.

4. MISCELLANEOUS

- 4.1 The parties shall fulfil their obligations and liabilities under this MoU.
- 4.2 Disagreements are to be settled in the spirit of partnership and with mutual respect. Sparkassenstiftung and Sparkasse OPR and the local partner institutions grant each other the right to terminate the cooperation in writing within one month's notice.
- 4.3 Detailed tasks shall be discussed and agreed in due time, taking this MoU as basis for the communication.
- 4.4 This MoU shall come into force upon the signing of the parties and remains effective until the 30th of November 2021, if there is no written request to amend or to renew.
- 4.5 Further extension of the period or renewal of this MoU is possible and shall be subject to mutual agreement between the parties.

4.6 The MoU is made on the 1st of November, 2018 in English in 4 original copies and in Mongolian in 4 original copies. Both the English and the Mongolian versions are of equal legitimate value.


BANK OF MONGOLIA



LKHAGVASUREN BYADRAN

Deputy Governor
Baga toiruu 3, Chingeltei district,
15160 Ulaanbaatar, Mongolia

SPARKASSENSTIFTUNG



NICLAUS BERGMANN

Managing Director
Simrockstrasse 4,
53113 Bonn, Germany


MONGOLIAN BANKERS ASSOCIATION



UNENBAT JIGJID

Executive Director and Secretary-General
Vista Office, Chinggis Avenue 17,
Sukhbaatar district, 15160 Ulaanbaatar,
Mongolia

SPARKASSE OSTPRIGNITZ-RUPPIN



MARKUS RÜCK

Chairman of the Board
Sparkasse Ostprignitz-Ruppin
Fontaneplatz 1, 16816 Neuruppin,
Germany